


...META*✓

Залуу шилжин ирэгсэдийн
асуудалдаархи нөхөрлөл

Inkluzivní škola.cz




ГАДААД ХҮҮХДҮҮДИЙН ЭЦЭГ ЭХЭД
ЗОРИУЛСАН СУРГАЛТ

ЧЕХ СУРГУУЛЬ

ЧЕХИЙН СУРГУУЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Чехийн боловсролын тогтолцоо



Цэцэрлэг (Mateřské školy, MŠ) – сургуулийн өмнөх боловсрол

- 3 – 6 настай хүүхдүүдэд зориулагдсан.
- Цэцэрлэгийн бүртгэл нь зохих журмын дагуу сургуулийн өмнөх боловсролын байгууллагад гаргасан өргөдөлийн дагуу хийгдэнэ.
- Бүртгүүлэхэд шаардлагатай баримтууд :
 - » Сургуулийн өмнөх боловсрол олгуулахаар гаргасан өргөдөл
 - » Хүүхдийн эмчийн дүгнэлт
 - » Хүүхэддээ урьдчилан сэргийлэх болон хугацаат тарилгуудыг хийлгүүлсэн тухай баримт
 - » Хуулийн хариуцагч (эцэг, эх)-ийн иргэний үнэмлэх буюу паспорт
 - » Гадаадын иргэдээс нэмэлт баримт шаардаж болно. Энэ тухай мэдээллийг хүүхдийн Хуулийн хариуцагч нь Цэцэрлэгийн эрхлэгчээс авч болно.
- Төлбөрийн төрлүүд:
 - » Сургуулийн өмнөх сургалтын төлбөр
 - » Хүүхдийн хоолны төлбөр

Ерөнхий боловсролын дунд сургууль-ЕБДС (Základní škola, ZŠ) - заавал олгогдох сургуулийн боловсрол

- 6 – 15 насандаа суралцана.
- Заавал олгогдох боловсролын сургалт нь 9 жил байна.
- ЕБДС-ийн 1 дүгээр ангийн бүртгэл - заавал олгогдох дунд боловсролын 1 дүгээр ангийн сурагчдын албан ёсны бүртгэл нь 1 дүгээр сарын 15-наас 2 дугаар сарын 15-ны хооронд явагдах боловч хүүхдүүдийг хэдийд ч бүртгүүлж болно.
- Хуулийн хариуцагч нь хүүхдийн ЕБДС-д суралцах хугацааг хойшлуулах талаар хүсэлт гаргаж болно.
- Бүртгэлд шаардлагатай баримтууд: хүүхдийн төрсөний гэрчилгээ, хуулийн хариуцагчийн паспорт, хүүхдийн эрүүл мэндийн даатгалын баримтууд.
- Дээд ангиудын бүртгэлийг хичээлийн жилийн хэдийд ч хийлгэж болно.
- Гэхдээ сүүлийн төгссөн ангийн дүнгийн баримтыг үзүүлэх шаардлагатай.

ЕБДС нь 2 шатлалтай байна:

1. шатлал 1- 5 дугаар анги /бага анги/

2. шатлал 6 – 9 дүгээр анги /ахлах анги/

→ Нэг ба хоёрдугаар шатлалын хоорондох шилжилт нь шууд хийгдэнэ.

- Заавал олгогдох боловсролын сургалтын зарим хэсгийг олон жилийн сургалттай гимназид суралцаж болно.
 - 8 жилийн сургалттай гимназид ЕБДС-ийн 5 дугаар анги төгссөн хүүхэд шалгалт өгөн элсэж болно.
 - 6 жилийн сургалттай гимназид ЕБДС-ийн 7 дугаар анги төгсөөд элсэнэ.
 - Өнөөдрийн мөрдөгдөж байгаа жураманд гимназийн элсэлтийн шалгалтыг чех хэл, математик, ерөнхий эрдмийн мэдлэгээр авдаг.

Төлбөрийн төрлүүд:

- Зарим хувийн болон шашны сургуулиудаас бусад дунд боловсрол олгох бүх ЕБДС нь төлбөргүй.
- Бэлтгэл ба 1 дүгээр ангийн сурагчдад 200 К᠑-той дүйцэх хэмжээний үнэ бүхий сургалтын материалыг төлбөргүй олгоно.
- Дэвтэр, үзэг, харандаа, шугам зэрэг хичээлийн хэрэгслийг сурагчид өөрсдөө худалдаж авна.
- Сурах бичиг, сургалтын ном материалыг үнэгүй олгох боловч, хичээлийн жилийн эцэст буцааж тушаах (нэгдүгээр ангиас бусад бүх ангийнхан) ёстой.
- Сургууль дээр явагддаг нэмэлт дугуйлан, секцүүд нь ихэнхи тохиолдолд төлбөртэй байдаг.
- Сургуулийн хоолны газарт төлбөртэй хооллоно.

Дунд сургууль – ирээдүйн мэргэжлийн бэлтгэл

- 15 наснаас ЕБДС-ийг төгсөөд дунд сургуульд орно.
- Дунд сургууль нь ЕБДС-ийн шууд үргэлжлэл бөгөөд ирээдүйн мэргэжил, цаашдын сургалтанд бэлтгэнэ.
- Сургуулийн сонголт нь сурагчийн сурлагын амжилт, өөрийн сонирголоос хамаарна.
- Сурагч нь өөрийн сонгосон сургуульдаа эхний элсэлтийн шалгалт өгөх мэдэгдэлээ 3 дугаар сарын 15-наас, нарийн мэргэжил, авъяас шаардсан сургуульд бол 11 дүгээр сарын 15-наас өмнө өгнө.
- Дунд сургууль нь гадаадын хүүхдүүдэд зориулан элсэлтийн чех хэлний шалгалтыг авахгүй байх эсвэл ярилцлага хэлбэрээр авч болно.
- Ихэнхи тохиолдолд дунд сургуульд суралцахад чех хэлний анхан шатны мэдлэгтэй байх шаардлага тавьдаг.

Дунд сургуулийн төрлүүд

Гимнази (Gymnázium) – ерөнхий эрдмийн бүрэн дунд боловсролыг нилээд гүнзгийрүүлсэн хэлбэрээр олгодог. Төгсөхдөө шалгалт (maturit) өгч гэрчилгээ авна. Гимнази нь дээд болон мэргэжлийн дээд сургуульд орох бэлтгэл болж өгдөг. Сургалтын хугацаа нь ихэнхи тохиолдолд 4 жил байна.

Тайлбар. Гимназид цаашид шууд дээд сургуульд орох зорилготой хүүхдүүд элсэн суралцдаг бөгөөл ерөнхий эрдмийн хичээлийг нилээд гүнзгийрүүлэн үздэг. Төгссөн тохиолдолд дээд сургуульд элсэх бололцоотой. Гэхдээ мэргэжил олгодоггүй.

Мэргэжлийн бүрэн дунд сургууль (Střední odborná škola) – бүрэн дунд боловсролыг мэргэжлийн хамт олгодог. Төгсөхдөө шалгалт өгнө. Мэргэжил нь техник-аж ахуй, эдийн засаг, эрүүл мэнд, боловсрол болон бусад чиглэлээр байна. Сургалтын хугацаа нь 4 жил байна.

Тайлбар. Энэ төрөл нь Монголын техникум, техник мэргэжлийн дунд сургуультай адил. Гимназиас ялгаатай нь ерөнхий эрдмийн хичээл арай бага ордог. Төгссөн тохиолдолд дээд сургуульд элсэх бололцоотой. Гэхдээ элсэж, суралцаж чадаагүй тохиолдолд эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах боломжтой.

Мэргэжлийн дунд сургууль (Střední odborné učiliště, SOU) – мэргэжлийн дунд боловсролыг олгодог. Төгсөхдөө мэргэжлийн шалгалт өгдөг. Суралцах хугацаа нь 2-3 жил байна. Сурагчид нь төгссөн мэргэжлээрээ мэргэжлийн үнэмлэх авах ба хүсвэл мэргэжлээрээ үргэлжлүүлэн суралцах боломжтой.

Тайлбар. Монголын системээр бол техник мэргэжлийн сургууль буюу одоогийнхоор сургалт үйлдвэрлэлийн төвтэй адил. Төгсөхдөө мэргэжил эзэмшиж гарна. Дээд сургуульд шууд элсэхгүй ба үүний тулд нэмж матуригийн сургалтанд хамрагдах шаардлагатай.

Мэргэжлийн дээд сургууль (Vyšší odborné školy, VOŠ) ба Их, дээд сургууль (Vysoké školy, VŠ)

- Мэргэжлийн өндөр зэрэг олгох матуритын (боловсролын зэрэг авах улсын шалгалт өгч тэнцсэн тохиолдолд матурит хийгдсэн Гэрчилгээ олгогддог) сургалт.
- Мэргэжлийн дээд сургууль (VOŠ) нь ихэвчлэн 3 жил сургана. Төгсөхдөө мэргэжлийн шалгалт өгөх бөгөөд дипломтой мэргэжилтэн (diplomovaný specialist- DiS) гэсэн зэрэг авна.
- Их, дээд сургууль (VŠ) нь ихэвчлэн 3 шатлалтай байна. Үүнд: Бакалавр (сургалт нь 3-4 жил), үргэлжлэн Магистр (1-3 жил), Доктор (3 жил).
- Зөвхөн их, дээд сургуульд л шинжлэх ухааны зэрэг авах боломжтой.
- **Элсэлтийн шалгалт** – бүрэн дунд боловсрол эзэмшсэн (матурит хийсэн) Гэрчилгээг үзүүлнэ. Гадаадад матурит хийсэн бол энэхүү гэрчилгээг албан ёсоор баталгаажуулсан байх шаардлагатай. Элсэлтийн шалгалтуудын төрөл нь элсэх сургууль, мэргэжлээс хамаарна.

Сургуультай холбогдолтой эцэг, эхийн үүрэг

- Заавал олгогдох боловсрол (ЕБДС)-ын сургалт нь 9 жил байх бөгөөд энэ хугацаанд хүүхдүүд албан журмаар сургуульд суралцах ёстой.
- Хичээлд ирээгүй тохиолдолд сурагч тайлбар гаргадаг. Сургууль бүр өөрийн онцлог бүхий дотоод журамтай бөгөөд энэхүү журамд энэ тухай тусгагдсан байдаг. Гэхдээ ямар ч тохиолдолд тайлбарыг хичээлд ирээгүй өдрийнхөө дараа өдөр нь гаргах ёстой. Хүүхэд жишээ нь, эмчилгээ хийлгэх бол эцэг эх нь чөлөөг сургуулийн захиргаанаас урьдчилан авах ёстой.
- Эцэг эхчүүд нь хүүхдийнхээ сурлагын явцад хяналт тавьж, сурагчийн дэвтэртэй тогтмол танилцаж байх үүрэгтэй бөгөөд энэ тухай багш нарт нь мэдүүлэхийн тулд дүн бүрийн ард гарын үсгээ зурж байна. Мөн хичээлийн хэрэгслийн иж бүрдэл, хичээлийн бэлтгэл, гэрийн даалгаврын биелэлтийг тогтмол хянаж байх үүрэгтэй.
- Сургуулиас эцэг эхийн хурлыг хийж хүүхдийн сурлага, сахилгын талаар мэдээллийг өгдөг. Энэхүү хурал нь ихэнхи тохиолдолд эцэг эхийг заавал ирэхийг шаардахгүй болов ч, хүүхдийнхээ төлөө сургууль, багш нартай хамтран ажиллахад их ач холбогдолтой.

Хичээлийн жилийн зохион байгуулалт

- Хичээл нь голдуу 8.00 цагт эхэлж, бага ангийнхан 12.30-аас хэтрэхгүй, ахлах ангийнхан үдээс хойш хүртэл хичээллэнэ. Бага ангийн сурагчид нь хичээлийн дараа өдөр өнжүүлэх (družina)-д үдээс хойшхи цагууд хүртэл байх боломжтой.

- Бүх төрлийн сургуулийн хичээлийн жил нь тухайн жилийн 9 дүгээр сарын 1-нд эхэлж, дараа жилийн 8 дугаар сарын 31-нд дуусдаг. Хичээлийн жил нь сургалтын ба амралтын үеүүдэд хуваагдана.

Сургалтын үе нь - 9 дүгээр сарын 1-нд эхэлж дараа жилийн 6 дугаар сарын 30-нд дуусна.

- Сургалтын үе нь **1 ба 2 дугаар хагас жилд** хуваагдана. 1 дүгээр хагас жил нь 9 дүгээр сарын 1-нээс дараа жилийн 1 дүгээр сарын 31 хүртэл, 2 дугаар хагас жил нь 2 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 30 хүртэл үргэлжилнэ. Сургалтын хагас жил бүрт сурагчид гэрчилгээ (vysvědčení) олгогдоно.

Сурагчдын амралт – чөлөөтэй үе.

- Намрын амралт – 10 дугаар сарын 28-ны Үндэсний баярын өдрүүдэд нэмж 2 хоног амрана.
- Шинэ жилийн амралт – 12 дугаар сарын 23-наас дараа оны 1 дүгээр сарын 2 хүртэл үргэлжилнэ.
- Хагас жилийн амралт – 1 хоног амрана. 1 дүгээр сарын 29-нээс 4 дүгээр сарын 2-ны хооронд аль нэг Баасан гаригт тохионо.
- Хаврын амралт – 7 хоног амрана. Сургуулийн байгаа хот, дүүргээс хамааран 2 дугаар сарын сүүлийн 7 хоногоос 3 дугаар сарын сүүлийн долоо хоногийн хооронд тохионо.
- Улаан өндөгний баярын амралт – Улаан өндөгний баярын өмнөх Пүрэв, Баасан гаригуудад тохионо.

Тайлбар. Улаан өндөгний баяр нь Ням ба Даваа гаригт дамжин тохиодог.

- Зуны амралт – 7 дугаар сарын 1-нээс 8 дугаар сарын 31 хүртэл үргэлжилнэ.
- Зохион байгуулалтын болон техникийн гэх мэт шалтгаанаар сургуулийн захирал нь сурагчдад амралтын өдрүүд олгож болно. Гэхдээ энэ амралт нь нэг хичээлийн жилд 5 хоногоос илүүгүй байна.

Хичээлүүд

Хэл ба хэл зүйн харилцаа

Чех хэл, уран зохиол

- Бага ангид – бичих, унших, ярих гэж хувааж үзнэ.
- Ахлах ангид – уран зохиол, хэл зүй, найруулга зүй гэж хуваана.
- Нэмэлт хэрэглэл шаардахгүй (дэвтэр, бичгийн хэрэгслээс гадна)

Гадаад хэл

- Голчлон англи ба немц хэл судалдаг. Тухайн сургуулиас хамааран орос, франц хэл үзэж болно. Голдуу бага ангид 1 гадаад хэл, ахлах ангиас 2 дахь гадаад хэл нэмэгдэж орж эхэлдэг.

Математик

- 10-тын системд тоог бодох (+, -, х, : үйлдлүүд), үл мэдэгдэгчийг үсгээр жишээлбэл, х-ээр тэмдэглэсэн тоонууд, геометрийн хичээлээр зөвхөн зурах бус бусад тооцоо (жишээлбэл, өнцгийн хэмжээ олох гэх мэт) хийх.

Хэрэгсэл: шугам, гурвалжин шугамууд, гортиг, тооны машин, өнцөг хэмжигч, зураг зурах харандаа гэх мэт.

Хүн - Дэлхий

Энэ төрлийн сэдэв нь нь бага ангид хэд хэдэн төрлийн хичээлээр орно.

- 1-3 дугаар ангид Анхны мэдлэг (Prvouka) – байгаль, хүмүүн, сургууль, эрүүл мэндийн гэх мэт чиглэлээр.
- 4 дүгээр ангиас энэ сэдэв нь байгалийн шинжлэлийн суурь болох - Байгалийн ухаан (Přirodověd), Чех улсын түүх, газар зүйн үндсийг судлах - Орон нутаг судлал (Vlastivěda) гэсэн 2 хичээл болон задарна.

Хүн - Нийгэм

Ахлах ангид Хүн – Дэлхий сэдэв нь өргөжин дараах хичээлүүд орно:

Түүх – Чех улсын эрт үеэс одоог хүртэлхи түүх, холбогдол бүхий дэлхийн түүх

Иргэний боловсрол – иргэний эрх зүй ба түүнтэй холбогдолтой асуудлуудыг судлана.

Хүн - Байгаль

Энэхүү төрлийн сэдэв нь хэдэн хэдэн хичээлээс бүрдэнэ.

Физик – Физикийн хуулиуд, цахилгаан, оптик гэх мэт. Хичээлийн буюу лабораторын ажлын эхэнд багш нь урьдчилсан зөвлөлгөө өгнө.

Хими – химийн элементүүд, урвал, урвалын явц, байгалийн дахь химийн гол бодисууд гэх мэт.

Биолог – микроорганизмийн ертөнц, ургамал ба амьтан судлал, хүний анатом гэх мэт сэдвүүд.

Зураг - Урлал

Хөгжмийн боловсрол – дуу, хөгжмийн нот, хөгжмийн зэмсэгүүд, хөгжмийн урлагийн бүтээлүүд гэх мэт

Урлан бүтээх боловсрол – зураг зурах, схем туурвих, урлан бүтээх төрөл бүрийн материал, техник хэрэгсэлтэй ажиллах гэх мэт.

Хүн – Эрүүл мэнд

Эрүүл мэнд – эрүүл амьдралын үндэс, тамхи, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх гэх мэт.


Биеийн тамир – төрөл бүрийн дасгалууд, бөмбөгт тоглоомууд,...

Хүн – Хөдөлмөрийн орчин

Хөдөлмөрийн хүмүүжил – Төрөл бүрийн материал ашиглах ажлууд.

Жишээлбэл, газар боловсруулах, хоол хийх, мэдээлэл зүйн болон бусад технологиуд ашиглах гэх мэт.

Мэргэжил сонголтын бэлтгэл – Зарим сургуульд ийм төрлийн хичээл ордог бөгөөд 8-9 дүгээр ангийн сурагчдад ямар сургуульд элсэн орох, ямар мэргэжил сонгох асуудлыг шийдвэрлэхэд нь тусалдаг.



Үг зүйн тайлбар

Сурагчийн дэвтэр (Žákovská knížka,ŽК) – сурагчийн дүн, сурагчид багшаас өгсөн сайшаал, зэмлэл зэргийг тэмдэглэсэн, багш-эцэг,эхийн харилцах дэвтэр

Бяцхан дэвтэр (Notýsek) – Бага насны хүүхдүүдийн хэрэглэдэг сурагчийн дэвтэр

Дүн (Známky) – Дүн нь 1 – 5 хүртэл байдаг бөгөөд хамгийн сайн дүн нь 1 (онцсайн-výborná), хамгийн муу нь 5 (хангалтгүй-nedostatečná)

Гэрийн даалгавар (Domáci úkol,DÚ) – гэртээ хийхээр багшаас сурагчид өгсөн гэрийн даалгавар. Сурагч нь даалгавараа хийгээд эцэг, эхийн гарын үсгийг зуруулсан байх ёстой.

Зэмлэл (Poznámka) – Сурагч буруу үйлдэл хийсэн тохиолдолд (сахилгагүйтэх, гэрийн даалгавар хийгээгүй ирэх, багшийг үл сонсох гэх мэт) багшаас өгсөн зэмлэл.

Сайшаал (Pochvala) – Хамт олондоо үлгэр дууриал болох, суралга, сахилга, спортын амжилт гаргах зэрэгт багш сурагчийг сайшаана.

Донго (Důtka) – Сургуулийн дотоод журмыг удаа дараалан зөрчсөн тохиолдод донгодно. Донгыг эхлээд ангийн багш, дараа нь захирал олгоно.

Тайлбар бичиг (Omluvenka) – Сурагч хичээлдээ очоогүй тохиолдолд шалтгааныг нь сурагчийн дэвтэрт бичиж явуулна.

Бичгийн ажил (Písemka) – Хичээлийн явцад мэдлэгийг шалгах бичгийн шалгалт, тест

10, 5 минутын тест (Desetimínutovka, pětímínutovka) – Богино хугацааны бичгийн шалгалт, тест

Цээж бичиг (Diktát) – Зөв бичгийг шалгасан бичгийн шалгалт

Аман шалгалт (Zkoušení) – Мэдлэг шалгах аман шалгалт

Сургуулийн дотоод зохион байгуулалт

Өдөр өнжүүлэх (Školní družina) – бага ангийн сурагчдыг хичээлийн дараа үлдээж, эцэг, эх нь ажлын дараа ирж авах хүртэл тоглуулах, даалгавар хийлгүүлэх зэргээр байлгадаг.

Сургуулийн хоолны газар (Školní jídelna) – Сурагчдад өдрийн хоол өгөх зориулалттай. Хоол нь төлбөртэй.

Ангийн багш (Třídní učitel) – Анги бүр нь сурагчдын зохион байгуулалттай үйл ажиллагаа, удирдлага хариуцсан анги удирдсан багштай байна.

Захирал (Ředitel) – Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа, зохион байгуулалтын асуудлуудыг хариуцан сургуулийг удирдана.

Гэрчилгээ (Vysvědčení) – Сурагчийн сурлагын дүн, сахилга батыг харуулсан баримт бичиг. Гэрчилгээг сурагч бүрт хичээлийн хагас жил болгонд олгоно.

Ангийн хурал (Třídní schůzky) – Голчлон хичээлийн хагас жил бүрт болох бөгөөд эцэг, эхчүүдэд хүүхдийнхээ сурлагын амжилт, сахилга батын талаар багш нартай нь нүүр тулан ярилцах боломж олгоно.

Амралт (Prázdniny) – Сурагчдын хичээлд явалгүй амрах өдрүүд.

Захирлын олгосон амралт (Ředitelské volno) – Захирал нь Хичээлийн жил бүр 5 хоногийн амралт олгох эрхтэй байдаг.

Аялал (Výlet) – Сургуулиас гадуур зохион байгуулалттайгаар аялах

Хувийн сургалтын төлөвлөгөө (Individuální vzdělávací plán, IVP) – Хэрэв сурагчдад нэмэгдэл хичээл оруулах шаардлагатай гэж үзвэл сургуулиас Хувийн сургалтын төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлдэг.